

БАТЛАВ
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН НИЙГМИЙН
САЛБАР, НОГООН ХӨГЖИЛ БОЛОН АГААР,
ОРЧНЫ БОХИРДЛЫН АСУУДАЛ ХАРИУЦСАН
ОРЛОГЧ, “УЛААНБААТАР МАРАФОН-2024”
ОЛОН УЛСЫН ГҮЙЛТИЙГ ЗОХИОН БАЙГУУЛАХ
АЖЛЫН ХЭСГИЙН ДАРГА
О.НОМИНЧИМЭГ

2024 оны 03 дугаар сарын 20

УДИРДАМЖ

2024 оны 03 дугаар сарын 13

Улаанбаатар хот

“УЛААНБААТАР МАРАФОН - 2024” ОЛОН УЛСЫН
ГҮЙЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ ТУХАЙ

Нэг.Зорилго:

1.1.Эх орондоо гүйлтийн спортыг хөгжүүлэх, нийслэл хотоо дэлхийн улс орнуудад сурталчлах, гүйлтээр хичээллэгч, сонирхогч иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, өсвөр залуу үеийнхнийг өөрийн дотоод нөөц боломжоо нээх, зорилгодоо хүрэх тэсвэр хатуужилтай болгох, бие бялдрын болон оюун санааны өв тэгш хүмүүжил төлөвшүүлэхэд “Улаанбаатар марафон-2024” олон улсын гүйлт (цаашид “Марафон гүйлт” гэх)-ийн гол зорилго оршино.

1.2.Хамрах хүрээ: Энэхүү марафонд Ерөнхий боловсролын сургуулийн сурагчид, их дээд сургуулийн оюутнууд, нийслэл, дүүргийн төрийн болон нутгийн захиргаа, аж ахуйн нэгж, байгууллагын ажилтнууд, гадаад, дотоодын гүйгчдийг хамруулна.

Хоёр.Марафон гүйлтийг зохион байгуулагчид:

Ерөнхий зохион байгуулагчид: Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Нийслэлийн Биеийн тамир, спортын газар

Хамтран зохион байгуулагчид: “Хай Пэймент Солюшнс” ХХК, Монголын Хөнгөн атлетикийн холбоо

Гурав.Зохион байгуулах журам, хугацаа:

3.1.“Улаанбаатар марафон-2024” олон улсын гүйлт 2024 оны 05 дугаар сарын 25-ны өдөр 09:30 цагт Улаанбаатар хотын Д.Сүхбаатарын талбайд болно.

Тэмцээний зай, төрөл, насны ангилал:

№	Төрөл	Насны ангилал	Ангилал	Дагалдах зүйлс
1.	42 км	18+ нас	эм, эр	энгэрийн дугаар, дурсгалын медаль, футболк, чип
2.		ХБИ 18+ нас	эм, эр	
3.	21 км	18-34	эм, эр	энгэрийн дугаар, дурсгалын медаль, футболк, чип
		35-54	эм, эр	
		55+	эм, эр	
4.		ХБИ 18+ нас	эм, эр	

5.	10 км	18+ нас	эм, эр	энгэрийн дугаар, дурсгалын медаль, футболк, чип
6.	5 км	12-17	Охид, хөвгүүд	энгэрийн дугаар
		(Эрүүл мэндийн гүйлт) 18-аас дээш нас		
7.	1,5 км	Тэргэнцэртэй	эм, эр	энгэрийн дугаар
		Хараагүй	эм, эр	
8.	1,5 км	Гэр бүл	Гэр бүлээрээ хүний тоо харгалзахгүй	энгэрийн дугаар
9.	500м, 800м	Тусгай олимпын төрөл	Тусгай олимпын иргэд	энгэрийн дугаар

3.2. Марафон гүйлтийн нээлтийн ажиллагаа 2024 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн 09:30 цагт Улаанбаатар хотын Д.Сүхбаатарын талбайд болно.

3.3. Марафон гүйлтийн гарааны байрлал

- 1-р шугамд: 42 км, 21 км-ийн зайн гүйгчид;
- 2-р шугамд: 10 км-ийн зайн гүйгчид;
- 3-р шугамд: 5 км-ийн 12-17 насны гүйгчид;
- 4-р шугамд: 5 км-ийн 18-аас дээш нас Эрүүл мэндийн гүйлтийн гүйгчид тус тус байрлан зогсоно.

3.4. Гараанаас гарах хугацаа 10:00 цагт нэгдсэн дохиогоор зэрэг гарна. Зай тус бүр тогтоосон маршрутаар гүйж Д.Сүхбаатарын талбайд барианд орно.

3.5. Бүтэн, хагас марафон буюу 42км, 21км гүйлтийн бүх төрөлд оролцогчдын гүйлтийн үргэлжлэх хугацаа 6 цаг байх бөгөөд тухайн өдрийн 16:00 цагаар хязгаарлагдана.

3.6. Тэргэнцэртэй, харааны бэрхшээлтэй оролцогчдын 1,5 км-ийн гараа 2024 оны 05 дугаар сарын 25-ны өдөр 13:00 цагт, гэр бүлийн гүйлт 14:00 цагуудад эхэлнэ.

Тус гүйлт нь Монгол Улсын их сургуулийн нэгдүгээр байрны урд талын гарааны шугамаас гарч Д.Сүхбаатарын талбайд барианд орно.

3.7. Тусгай олимпын төрөлд оролцогчдын 500м, 800м-ийн гараа 14:30-15:00 цагийн хооронд тусгай хөтөлбөрийн дагуу Монголын тусгай олимпын хороо болон шүүгчдийн бүрэлдэхүүн зохион байгуулна.

3.8. Марафон гүйлтийн 42 км, 21 км, 10 км-ийн зайн гүйлтэд оролцогчдын амжилтыг <https://ubmarathon.hipay.mn/> цахим хуудсанд байршуулна.

Бүх оролцогчид марафон гүйлтэд оролцсон "Батламж"-аа дээрх цахим хуудаснаас өөрсдөө хэвлэж авах боломжтой.

3.9. Дүүргүүдийн Засаг даргын Тамгын газар марафон гүйлтийн маршрутын дагуу хуваарилагдсан талбайд иргэдэд зориулсан урлаг, спорт, хүмүүнлэгийн арга хэмжээ зохион байгуулна.

Дөрөв. Бүртгэлийн ажиллагаа, хураамж

4.1. Марафон гүйлтэд оролцогчид <https://ubmarathon.hipay.mn/> цахим хуудас болон hipay аппликэйшнаар бүртгүүлж онлайнаар хураамжаа төлсөн байна.

4.2. Бүртгүүлсэн гүйгчид бүртгэлийн цэгт очиж энгэрийн дугаар авснаар гүйлтэд оролцох эрх нь баталгаажна.

4.3. Гүйлтэд оролцогчийн иргэний үнэмлэх, гадаад паспорт, төлбөрийг <https://ubmarathon.hipay.mn/> цахим хуудас, hipay аппликэйшнаар хийсэн баримтыг үндэслэн энгэрийн дугаар олгож бүртгэл баталгаажсанаар гүйлтэд оролцох эрх нээгдэнэ.

4.4. Дотоод, гадаадын гүйгчдийн бүртгэлийн хураамжийн мэдээлэл

Гүйлтийн зай	1,5 км	5 км	10 км	21 км	42 км
Төлбөр	5,000₮	5,000₮	30,000₮	50,000₮	60,000₮

4.5.Гүйгчдийн бүртгэлийн хураамж нь төсөвт төвлөрдөг тул сугалааны болон НӨАТ-ын баримт олгогдохгүй.

4.6.Марафон гүйлтийн бүртгэл 2024 оны 03 дугаар сараас 20-ны өдрөөс 05 дугаар сарын 20-ны өдрийн 17:00 цаг хүртэл зохион байгуулагдана.

4.7.Марафон гүйлтийн 5 км-ийн зайд оролцогчийн энгэрийн дугаар олгох ажил дараах байршилд 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс 05 дугаар сарын 20-ны өдрийн 17:00 цаг хүртэл зохион байгуулна.

- Нийслэлийн Биеийн тамир, спортын газар - Утас:90098082;
- Баянгол дүүргийн Биеийн тамир, спортын хороо - Утас:91990368;
- Баянзүрх дүүргийн Биеийн тамир, спортын хороо - Утас:88110981;
- Багануур дүүргийн Биеийн тамир, спортын хороо - Утас:99407709;
- Багахангай дүүргийн Биеийн тамир, спортын хороо - Утас:96770415;
- Налайх дүүргийн Биеийн тамир, спортын хороо - Утас:89130213;
- Хан-Уул дүүргийн Биеийн тамир, спортын хороо - Утас:99108616;
- Сүхбаатар дүүргийн Биеийн тамир, спортын хороо - Утас:91148009;
- Сонгинохайрхан дүүргийн Биеийн тамир, спортын хороо - Утас:99072560;
- Чингэлтэй дүүргийн Биеийн тамир, спортын хороо - Утас:86874487.
- Жанжин Сүхбаатарын талбай – Утас:94114841
- Улсын Их дэлгүүрийн урд талбай - Утас:95456121

4.8.Марафон гүйлтийн 42 км, 21 км, 10 км-ийн зайд оролцогчийн (гадаад, дотоодын иргэд) энгэрийн дугаар, чип, футболк олгох ажил Нийслэлийн Биеийн тамир, спортын газар (Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Ж.Самбуугийн гудамж, Бага тойруу, Нийслэлийн Засаг захиргааны 4-р байрны нэгдүгээр давхарт буюу “Зоос гоёл”-ын замын урд) 2024 оны 05 дугаар сарын 15-ны өдрөөс 05 дугаар сарын 20-ны өдрийн 17:00 цаг хүртэлх хугацаанд зохион байгуулагдана. Утас:70002785, 7766-7700 (hipay), 99285651, 90098082, 96635753.

4.9.Марафон гүйлтийн 5 км-ийн зай, 12-17 насны ангилалд 2007 оны 01 дүгээр сарын 01-нээс хойш төрсөн, 2012 оны 12 дугаар сарын 31-нээс өмнө төрсөн хүүхдүүд оролцоно.

4.10.Марафон гүйлтийн 1,5км-ийн зайд оролцогчийн баталгаажуулалт, энгэрийн дугаар олгох ажил Нийслэлийн Биеийн тамир, спортын газарт 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс 05 дугаар сарын 20-ны өдрийн 17:00 цаг хүртэл зохион байгуулна.

4.11.Гэр бүлийн гүйлтийн 1,5 км-ийн зайд хүний тоо харгалзахгүй гэр бүлээрээ оролцоно. Бүртгэлийг <https://ubmarathon.hipay.mn/> цахим хуудсаар бүртгэж энгэрийн дугаар олгож баталгаажуулна. Гүйлтэд оролцсон гэр бүлийн дурсгалын зургийг “Батламж”-ийн хамт олгоно.

4.12.“Улаанбаатар марафон-2024” олон улсын гүйлтийн 500м, 800м зайд тусгай олимпын харьяаллын гүйгчид оролцох бөгөөд бүртгэлийг Монголын тусгай олимпын хороо бүртгэнэ.

800м-ийн зайн гараа нь Спортын төв ордны баруун талын төв замаас, 500м-ийн зайн гараа нь Улаанбаатар зочид буудал өмнөх төв замаас гарч Д.Сүхбаатарын талбайд барианд орно.

4.13.Марафон гүйлтийн энгэрийн дугаар аваагүй оролцогчдыг барианд барихгүй бөгөөд үзүүлсэн амжилт, хугацааг тодорхойлохгүй.

4.14.Бүртгэл, хураамжтай холбоотой мэдээллийг <https://ubmarathon.hipay.mn/>, sport.ub.gov.mn цахим хуудас, hipay аппликэйшнаас авна. Утас:70002785, 7766-7700 (hipay), 90098082, 99285651,

4.15.Марафон гүйлтийн тэмцээний бүх насны ангилалд оролцогчид эмчийн үзлэгт хамрагдан зүрхний цохилт, даралтаа хэмжүүлсэн байна. Хэвийн бус тохиолдолд гүйлтэд оролцохгүй ба оролцсон тохиолдолд хариуцлагаа хувь хүн өөрөө хүлээнэ.

4.16.Марафон гүйлтэд оролцогчдын байр, хоол, ирэх, буцах унаа болон бусад холбогдох зардлыг тэмцээнд оролцуулж байгаа тухайн байгууллага, хувь хүн хариуцна.

4.17.Марафон гүйлтийн тэмцээн зохион байгуулах өдөр буюу 2024 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн 06:00 цагт гүйлтийн маршрутын дагуу замуудын орох, гарах хөдөлгөөнийг хязгаарлах тул гүйлтэд оролцогчид тээврийн асуудлаа зохицуулж Д.Сүхбаатарын талбайд 09:00 цагаас өмнө ирж гарааны шугамын ард байраа эзэлсэн байна.

4.18.2024 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн 06:30-07:00 цагийн хооронд хагас, бүтэн марафонд оролцогчдын тэжээлийг гараа, бариа дээр хүлээн авч тусгай 2 цэгт байршуулна. Хоцорсон тохиолдолд хүлээн авахгүй. Тамирчид тэжээлийн сав дээр өөрсдийн энгэрийн дугаар, таних тэмдэг хийж хураалгана.

Тав. Шагнал урамшуулал:

5.1.Марафон гүйлтийн 42км (18-аас дээш нас), 21 км (18-34 нас, 35-54 нас, 55-аас дээш) 10 км зайд эхний I-III байрт шалгарсан эрэгтэй, эмэгтэй тамирчдад цом, алт, мөнгө, хүрэл медаль, мөнгөн шагнал, өргөмжлөлөөр, IV-X байр эзэлсэн гүйгчдийг дурсгалын медаль, өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнана.

5.2.Хөгжлийн бэрхшээлтэй иргэд (харааны бэрхшээлтэй, хэл яриа, сонсголын бэрхшээлтэй, саажилт, тулгуур эрхтний бэрхшээлтэй гэх мэт)-ийн (42км, 21км)-ийн гүйлтэд гүйж эхний I-III байрт шалгарсан тамирчдад цом, алт, мөнгө, хүрэл медаль, мөнгөн шагнал, өргөмжлөлөөр, IV-V байр эзэлсэн гүйгчдийг дурсгалын медаль, өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнана.

5.3.Марафон гүйлтийн 5 км-ийн зайд 12-17 насны эхний I-III байрт орсон охид, хөвгүүдийг өргөмжлөл, цом, алт, мөнгө, хүрэл медаль, өргөмжлөл, мөнгөн шагналаар, IV-VIII байрт шалгарсан тамирчдыг дурсгалын медаль, өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнана.

5.4.Марафон гүйлтийн 1,5 км-ийн зайд тэргэнцэртэй, хараагүй иргэдийн төрөлд гүйж эхний I-III байрт шалгарсан эрэгтэй, эмэгтэй тамирчдыг цом, алт, мөнгө, хүрэл медаль, өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнана.

5.5.Марафон гүйлтийн 500м, 800м зайд тусгай олимпын тамирчид гүйж эхний I-III байрт шалгарсан эрэгтэй, эмэгтэй тамирчдыг цом, алт, мөнгө, хүрэл медаль, өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнана.


ХЯНАСАН:

НИЙСЛЭЛИЙН БИЕИЙН ТАМИР
СПОРТЫН ГАЗРЫН ДАРГА

Ж.ГАНБОЛД

БОЛОВСРУУЛСАН:

НИЙСЛЭЛИЙН БИЕИЙН ТАМИР
СПОРТЫН ГАЗРЫН СПОРТ,
НИЙТИЙН БИЕИЙН ТАМИРЧИН
ХЭЛТСИЙН ДАРГА



С.САРАНЦЭЦЭГ